

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ ХАМААРАЛ БҮХИЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ
(2022 оны жилийн эцсийн байдлаар)**

ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт	д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага, Хэрэгжүүлэх	Нийт хөрөнгийн эх үүсвэрхэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц 2021-2022	Хэрэгжилт хувь
						Зорилтот түвшин, үр дүнгийнүзүүлэлт	Төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)		
1	2	3	4-5	6-7	8	9	10	11	12	13
5. Ногоон хөгжлийн бодлого										
5.1.Ногоон хөгжил. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.										
5.1.1.Улаанб аатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ	2	Томоохон хот, суурин газруудад агаарын чанарыг 5-аас доошгүй үзүүлэлтээр хянах боломжийг бүрдүүлнэ.	ХБТХ ОХ 2021 2024	Орон нутгийн төсөв		Агаарын бохирдлыг олон үзүүлэлтээр тасралтгүй автоматараар			Агаар бохирдуулагч эх үүсвэрийн хэмжилт судалгааг үр дүнтэй зохион байгуулах үүднээс аймгийн УЦУОШГ-ын байгаль орчны лабораторийн Testo 350, агаар дахь тоос тоосонцор хэмжигч DustTrak-8530 багажаар Арвайхээр сумын агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO ₂), азотын давхар исэл (NO ₂), PM _{2.5} , PM ₁₀ , нийт тоосонцорын агууламжуудыг тодорхойлж байна. Арвайхээр сумын агаарын чанарыг 1 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO ₂), азотын давхар исэл (NO ₂), PM _{2.5} тоосонцор болон цаг уурын үзүүлэлтүүдийг тодорхойлж байна. Арвайхээр сумын PM _{2.5} тоосонцор, хүхэрлэг хий, азотын давхар ислийн агууламжийг тус бүр нь 284 удаагийн сорьц авч MNS17.2.5.12-88, MNS 17.2.5.11-88 стандартын дагуу тодорхойлж 1-5-р сарын агаар дахь бохирдуулах бодисын агууламжаар хүхэрлэг хий /SO ₂ / -ийн дундаж агууламж 50 мкг/м ³ , хамгийн их нь 507 мкг/м ³ , азотын давхар ислийн /NO ₂ /-ийн дундаж агууламж 27 мкг/м ³ , хамгийн их нь 166 мкг/м ³ , PM _{2.5} тоосонцорын дундаж агууламж 77 мкг/м ³ , хамгийн их нь 248 мкг/м ³ байгаа нь MNS 4585:2016 агаарын чанарын стандартын хүлцэх агууламжтай харьцуулахад хүхэрлэг хий /SO ₂ /-ийн дундаж агууламж 5 дахин их, PM _{2.5}	50

								тоосонцорын дундаж агууламж 3,1 дахин их давсан бохирдолтой байна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Өвөрхангай аймгийн Засаг даргын хамтарсан 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/475, А/ тушаал, захирамжаар Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журмыг шинэчлэн батлагдсан. Арвайхээр сумын агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан шахмал түлш хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн Эмтийн 2 дугаар багийн нутаг дэвсгэрийг хамруулж тухайн нутаг дэвсгэрт байгаа айл өрхүүд журмын хэрэгжилтийг хангаж журмыг мөрдөж агаарын чанарыг сайжруулна.	
5.1.4.Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	1	Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.	ХБТХ ОХ 2021 2024	Орон нутгийн төсөв		Стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламж, дэд бүтцийн хэмжээг нэмэгдүүлнэ-		-Азийн хөгжийн банк болон орон нутгийн төсвийн 480,0 сая төгрөгийн санхүүжилтээр “КА-9100-МОН” төслийн хүрээнд Арвайхээр сумын 13 багийн 283 өрх тус төсөлд хамрагдаж сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон. 2021 онд голын хамгаалалтын бүс болох Онги, Дайргын голын орчимд стандартын шаардлага хангасан 3 ширхэг хөрсөнд үл нэвчих, сайжруулсан нийтийн ариун цэврийн байгууламж, хог хуримтлуулах бункер хийж байршуулсан. -2022 онд Өвөрхангай аймгийн хэмжээнд гэр хорооллын айл өрх болон албан байгууллагууд өөрсдийн санаачилгаар нүхэн жорлонгоо сайжруулж, хөрсөнд үл нэвчих 1043 ширхэг ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулсан. -Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2022 онд аялал жуулчлалын эвент арга хэмжээнд зориулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 38,0 сая төгрөгөөр 17 суултуур бүхий 3 ш зөөврийн эко ариун цэврийн байгууламж худалдан авч эвент арга хэмжээнүүдэд ашиглаж байна.	70
5.1.6.Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авна.	1	Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгаа хийж, өргөжүүлнэ.	БОАЖ Г 2021 2024	Улсын төсөв		Тусгай хамгаалалтанд авах ажлыг зохион байгуулах		-Өлзийт сумын Сангийн далай орчмын 6560 га талбайг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04/05 дугаар тогтоолоор аймгийн тусгай хамгаалалтад авч, тухайн газарт мөрдөх дэглэмийг баталсан. -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Хүнс, Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хорооны 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Онги, Таац голын урсац бүрэлдэх эх бүхий Уянга, Зүүнбаян-Улаан, Хужирт, Нарийнтээл сумдын нутагт орших “Хангайн нуруу”-ны салбар уулсын үзүүр төгсгөл хэсгийг улсын тусгай хамгаалалтад авах саналыг хэлэлцүүлж, Зүүнбаян-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дэмжсэн санал ирүүлээгүй тул дахин хэлэлцүүлэхээр хойшлуулаад байна.	90
5.1.7.Ховор амьтан, ургамлыг зориудаар өсгөн	1	Ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац нөөцийг үе	ХБТХ ОХ 2021 2024	Улс, орон нутгийн төсөв хувийн хөрөнгө		Ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац		-Аймгийн хэмжээнд байгалийн ургамлын тархац, нөөцийн судалгаа хийлгэх ажлыг ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнтэй гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн. Судалгааны ажлын хүрээнд аймгийн нийт 4984 км маршрутын дагуу хээрийн	100

үржүүлж, ашиглалтын нөөц бий болгоно.		шаттайгаар тогтооно.				нөөцийг үе шаттайгаар тогтооно.			судалгааны ажлыг явуулсан. Судалгааны үр дүнгээр 61 овгийн 238 төрлийн 517 зүйл ургамал бүртгэгдэж, нэн ховор ургамлын 12 овгийн 13 зүйл ургамлын 48 тархацын цэг, ховор ургамлын 17 овгийн 31 зүйл ургамал, эмийн болон хүнсний ашиглалтад өртөж буй 111 зүйл ургамлын 1059 тархцын цэгийг тогтоосон байна.	
5.1.8.Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.	1	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.	ХБТХ ОХ 2021 2024	Улс, орон нутгийн төсөв хувийн хөрөнгө		Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийсэн байна			-Ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Баярсголд” ХХК, “Өгөөмөр-Өргөө” ХХК, “АУМ-Алт” ХХК-иуд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг тухайн жилийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заагдсан хэмжээгээр хийж гүйцэтгэсэн. Үүнд дээрх аж ахуйн нэгжүүд 2021 онд техникийн нөхөн сэргээлтийг 67.49 га, биологийн нөхөн сэргээлтийг 7 га талбайд, 2022 онд техникийн нөхөн сэргээлтийг 55.5 га, биологийн нөхөн сэргээлтийг 10.5 га талбайд буюу нийт 140.49 га талбайд хийж аймаг, сумын ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.	90
5.1.9.Байгаль д ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжиж, хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх, аюултай хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулна.	1	Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулна.	ХБТХ ОХ 2021 2024	Улс, орон нутгийн төсөв		Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулах газрын асуудлыг шийдвэрлэсэн байна.			-Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулах газрын асуудлыг аймгийн зүгээс шийдвэрлэж, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос “Өвөрхангай, Булган, Архангай аймгуудад аюултай хог хаягдлыг хадгалах, агуулахын жишиг зураг, төсөв боловсруулж батлуулах, стандартын шаардлага хангасан аюултай хог хаягдлын агуулахыг барих” нээлттэй тендерийг 2021 онд зарлаж гүйцэтгэгчээр “ЖАМ” ХХК шалгарч Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай гэрээ байгуулан агуулахын барилгын ажил одоогийн байдлаар 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус барилгын ажилд орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын зүгээс 2 удаагийн хяналт тавьж ажилласан.	90
5.1.11.“Хөх морь” төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-	1	Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Онги, Хэрлэн усан цогцолборын төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.	ХБТХ ОХ 2021 2024	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж		Онги голын урсацыг сайжруулах төслийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлж, 10%-д хүргэсэн байна.			Орхон голоос эх авч Онги голын урсацыг нэмэгдүүлэн Улаан нуурыг тэтгэж, улмаар говийн бүсийн сум суурингийн хүн ам, бэлчээр, хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн ус хангамжийн найдвартай эх үүсвэр бий болгох, эрчим хүч үйлдвэрлэх зорилготой “Орхон-Онги” эко төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан. Тус төслийн ТЭЗҮ-ийг “Хайдродизайн прожект” ХХК, “Престиж инженеринг” ХХК, “Монхидро констракшн” ХХК, “Жедр” ХХК-иуд хамтран гүйцэтгэсэн.“Орхон-Онги” эко төслийн зураг төсвийн үнэ болох 6,8 тэрбум төгрөгийг 2023 оны төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн.	50

Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	2	Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулна.	ХБТХ ОХ 2021-2024	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж					-2021-2022 онд орон нутаг болон хувийн хэвшлийн хөрөнгөөр 13 суманд нийт 62 булаг, шанд, рашааны эхийг хашиж хамгаалан нутгийн иргэдэд хариуцууллаа. -Нарийнтээл сумын "Их булаг" хэмээх газарт хөв цөөрөм байгуулах зураг төсөл боловсруулах ажлыг усны мэргэжлийн байгууллага "Гидрофонтан" ХХКомпани 2022 оны 6-9 сард гүйцэтгэж хүлээлгэн өгсөн бөгөөд хөв цөөрөм байгуулах ажлын төсөвт өртөг болох 396,8 сая төгрөгийн санхүүжилтийг "Баян тээг" ХК-ний хөрөнгөөр 2023 онд хийлгүүлэхээр төлөвлөж байна.	90
5.1.12.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.	1	Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх Доплерын Радарын станц байгуулна.	ХБТХ ОХ 2020-2024	Улсын төсөв 5.9 тэрбум					Хэрэгжих хугацаа болоогүй	-
	2	Ус, цаг уурын хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, техник, технологийн шинэчлэл хийж, чадавхыг бэхжүүлнэ.	ХБТХ ОХ 2021-2024	Улсын төсөв 40.0 сая				Автомат станц, хэмжих хэрэгсэл уурын харуулын хангасан байна.	Ус цаг уурын хяналт, шинжилгээний сүлжээний техник, технологийн шинэчлэлийн хүрээнд Бүрд, Зүйл, Өлзийт, Баянгол, Сант, Гучин-Ус, Нарийнтээл, Хайрхандулаан, Уянга, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан сумдад тус бүр 15,0 сая төгрөгийн өртөгтэй шинжилгээний автомат төхөөрөмж суурилуулан судалгаа, хэмжилтийн ажлыг эхлүүлээ. Байгаль орчны шинжилгээний лабораторид агаарын бохирдол хэмжих PURPLE AIR хэрэгсэл 24 цаг тасралтгүй ажиллаж 5 үзүүлэлтээр хэмжиж байна. Хархорин сумын Агро цаг уурын салбарт таримал ургамлын талбайн хөрсний чийг тодорхойлох автомат багаж ZL-6-г суурилуулан хэмжилт хийж байна.	100
6.2.9.Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулна. Аймгийн төвүүдийн гэр хорооллын айл өрхүүдийг ухаалаг тоолуурт шилжүүлж, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг	1	Бүс нутгийн томоохон уурхайнуудыг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих ТЭЗҮ боловсруулах, бодлогын дэмжлэг үзүүлнэ.	ХБТХ ОХ 2021-2024	Улс, орон нутаг, орон нутгийн өмчит компанийн төсөв				Хөрөнгө оруулалт шийдвэрлэгдсэн байна.	Баянтээгийн нүүрсний уурхайг түшиглэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хурлаар "Баянтээг түлш" орон нутгийн өмчит ХХК байгуулагдаж, Эрчим хүчний яамны шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар ТЭЗҮ батлагдан сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж хэрэглээнд нэвтрүүлээд байна. 2021-2022 онд 842 тонн шахмал түлш үйлдвэрлэн Арвайхээр сумын Эмтийн 2 дугаар багийн 500 айл өрхийн хэрэглээнд нэвтрүүлж, угаар мэдрэгч төхөөрөмжийг суурилуулж, аюулгүй, хэвийн ажиллагааг хангах зааварчилгаа өгч, хяналт тавин ажиллаж байна. 2022 онд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2.0 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулагдсан. Уг гэрээний дагуу үйлдвэрийн өргөтгөл, олон үйлдэлт зуух, хатаалгын төхөөрөмжийн угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Блейз тек" ХХК гэрээ байгуулж, гүйцэтгэл 40 хувь, 300 тн шахмал түлш нөөцлөх агуулахын барилгын ажлын гүйцэтгэгчээр "Шоо констракшн" ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 70 хувьтай явагдаж, гүйцэтгэлээр ОББҮХ-оос тус тус санхүүжилтээ аваад байна. Мөн ОББҮХ-оос 11 дүгээр сард гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, дэмжлэгийг 660.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Тухайн санхүүжилтээр "Баянтээг	70

үзүүлж, агаарын бохирдлыг бууруулна.								түлш” ОНӨХХК-ийн үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, түүхий эд, материалын зардалд зарцуулахаар төлөвлөсөн. Дээрх барилга угсралт, тоног төхөөрөмжийн өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдсэнээр тухайн үйлдвэр цагт 10 тн кокс, 10 тн шахмал түлш гаргах хүчин чадалтай болж, үйлдвэрийн байраа халаах, халуун ус үйлдвэрлэх боломж бүрдээд байна.	
6.2.10. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	1	Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	ХБТХ ОХ 2021 2024	Орон нутгийн төсөв		Үе шаттайгаар хэрэгжүүлнэ.		<p>-“Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ 2021 оны 10 дугаар сараас эхлэн “Хаягдал хуванцар дахин боловсруулах” үйлдвэр байгуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Үйлдвэрийн тогтвортой үйл ажиллагааг хангахаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийтийн эзэмшлийн талбайд тарих мод, бутны хамгаалалтын хашааг 18,0 сая төгрөгийн хуванцар шонгоор хийж, нягтруулах пресслэгч төхөөрөмжид 15 сая төгрөгийг зарцуулаад байна.</p> <p>-Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй Арвайхээр сумын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслөөр Арвайхээр суманд пүү болон хоёрдогч түүхий эд хүлээн авах 5 цэгийг шинээр байгуулж, “Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн. Уг төслийн хүрээнд бичил тэтгэлэг зарлагдаж, “Эрүүл амьдрал” төсөл, “Үнсэн блок үйлдвэрлэх” төсөл, “Хаягдал сүүний савыг дахин ашиглах” зэрэг төслүүдэд тус бүр 5000 ам.доллар, “Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын “Арвайхээр суманд ногоон ажлын байр бий болгох, хаягдал хуванцар сав, гялгар уутыг дахин боловсруулж, хашааны шон, нүхэн жорлонгийн кольцо зэрэг нийгмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх” төсөлд 15,000 ам.долларын тэтгэлэгийг тус тус олгоод байна.</p> <p>- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг айл өрхүүдэд хэвшүүлж, дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх ажлын хүрээнд 13 суманд хоёрдогч түүхий эд хүлээн авах 28 цэг байгуулагдаж, 301,8 тн дахивар хаягдлыг цуглуулан аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг “Эко цэнэ”, “Цэмцгэр” төвүүд болон Улаанбаатар хот руу нийлүүлээд байна.</p> <p>-Есөнзүйл, Гучин-Ус, Баян-Өндөр, Уянга, Бүрд, Арвайхээр сумд 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн 69,0 сая төгрөгийн хөрөнгөөр хоёрдогч түүхий эдийг нягтруулах пресслэгч төхөөрөмжийг худалдан авсанаар аймгийн хэмжээнд 12 сум, 19 пресслэх төхөөрөмжтэй болоод байна.</p> <p>-“Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй Арвайхээр хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд Арвайхээр суманд пүү болон хоёрдогч түүхий эд хүлээн авах 5 цэгийг шинээр байгуулж, “Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн.</p>	100
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ									81,8

